



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДЭД ХОРООНЫ
ТОГТООЛ

2016 оны 2 сарын 3 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Чиглэл өгөх тухай

Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны 2016 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Засгийн газар болон Нийслэлээс агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр 2016 онд хийгдэж байгаа болон хийхээр төлөвлөгдөж буй ажлууд, Хүүхдийн эрүүл мэндэд агаарын бохирдлын үзүүлэх нөлөө, шийдвэрлэх арга зам Олон Улсын зөвлөгөөнөөс гарсан үр дүнгийн талаарх мэдээллийг сонсоод Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооноос ТОГТООХ нь:


Нэг.Дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд, Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дарга Ч.Сайханбилэгт чиглэл болгосугай:

1/Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхүүдийн халаалтыг ойрын 5 жилд багтаан нүүрсгүй горимд шилжүүлэх талаар шийдвэртэй арга хэмжээг авах ажлын төлөвлөгөө боловсруулж танилцуулах;

2/Агаарын бохирдлыг бууруулах асуудлын хүрээнд нүүрсгүй халаалтын технологийг нэвтрүүлж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийг дэмжих, тэдгээрийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөнгөлөлттэй зээл олгох, урамшуулах асуудлыг судлаж, шийдвэрлэх.

Хоёр.Энэ тогтоолоор өгсөн чиглэлийн биелэлтийг Дэд хороонд 2016 оны 3 дугаар сард багтаан танилцуулсугай.

АГААРЫН БОХИРДЛЫГ
БУУРУУЛАХ АСУУДЛЫН
ДЭД ХОРООНЫ ДАРГА



Ц.ОЮУНГЭРЭЛ